<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>0</b>	<b>7,791.00</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	0	441
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	0	7,350

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	162	162
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	69	69
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	46	46
650010	Гэрээт ажилтан	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>144,803,950.00</b>	<b>182,895,402.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>144,803,950.00</b>	<b>182,895,402.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>114,603,950.00</b>	<b>113,141,134.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>23,141,590.00</b>
210102	Нэмэгдэл		23,141,590.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>2,972,583.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		2,972,583.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>2,539,187.00</b>
210401	Бичиг хэрэг		433,822.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,241,997.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		863,368.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>4,977,335.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		4,977,335.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>1,008,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		1,008,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>114,603,950.00</b>	<b>10,628,944.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,603,950.00	10,628,944.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>67,873,495.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		67,309,495.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		564,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,200,000.00</b>	<b>69,754,268.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,200,000.00</b>	<b>58,649,268.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,200,000.00	28,049,268.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	30,600,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>11,105,000.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,105,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>144,803,950.00</b>	<b>182,895,402.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>144,803,950.00</b>	<b>182,895,402.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,230,250.00	25,905,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,560,800.00	80,118,958.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,562,300.00	10,577,844.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	32,450,600.00	66,293,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0</b>	<b>0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, дотоод хяналт, бараа материалын тайлан гаргалт, шатахууны тооцоо бодох, алданги тооцох, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 03 дугаар сарын 18-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Үенч сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/81 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үенч сумын засаг дарга нь “Хүний хөгжлийг дэмжсэн стандарттай Үенч сумын төлөө хамтдаа” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- *Ковид цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах*
- *Эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир спорт гэсэн дэд хөтөлбөрийг хөгжүүлэх*
- *Хөдөлмөр нийгэм хамгаалах зорилгоор ард иргэдийг хөгжүүлэх*
- *Эдийн засгийн хүрээнд санхүү төсвийн зохицуулалт, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод хэмнэлттэй зарцуулах*
- *Засаглалын бодлогын хүрээнд цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажиллах*
- *Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд байгаль хамгаалах нөхөрлөлийн тоог нэмэгдүүлэх, газар тариалангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөрсний доройтлыг сэргээх, хамгаалах,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Үенч сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 4085.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 61.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 49.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үенч сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 341.6 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр цэвэр өмчийн данснууд байна. Санхүүгийн байдлын тайланг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан /сая. төгрөг/*

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	149.1	223.2	(74.1)	149.7
Авлага	360.5	267.3	93.2	74.1
Бараа материал	133.1	133.2	(0.1)	100.1
Үндсэн хөрөнгө	7,660.0	8,020.6	(360.6)	104.7
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,302.7</b>	<b>8,644.3</b>	<b>(341.6)</b>	<b>104.1</b>
Богино хугацаат өр төлбөр	38.3	19.7	18.6	51.4
Цэвэр хөрөнгө, өмч	8,264.4	8,624.6	(360.2)	104.4
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,302.7</b>	<b>8,644.3</b>	<b>(341.6)</b>	<b>104.1</b>

*Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 149.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 223.2 сая төгрөг болж 74.1 сая төгрөгөөр буюу 49.7 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 223.2 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 360.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 267.3 сая төгрөг болж 93.2 сая төгрөг буюу 25.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		10.5	10.0 (0.5)
Байгууллагаас авах авлага		26.9	8.5 (18.4)
Хувь хүмүүсээс авах авлага		7.2	26.6 19.4
Урьдчилж гарсан зардлын авлага		85.8	85.8 -
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага		230.1	108.3 (121.8)
Татаас санхүүжилтийн авлага		-	28.1 28.1
<b>Дүн</b>		<b>360.5</b>	<b>267.3 (121.3)</b>

*Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд 267.3 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг ОНХС-ийн урьдчилж гарсан зардлын авлага 85.8 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээл 108.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага, бусад 73.2 сая төгрөгийн байгууллага хүмүүстэй холбоотой авлагууд эзэлж байна. Эзэн холбогдогч нь тодорхой бус, насжилт өндөртэй 14.7 сая төгрөгийн авлага шийдвэрлээгүй байна. Оны эхэнд 230.1 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 122.7 сая төгрөгийн зээл төлөгдөж 1.6 сая төгрөгийн өмгөөлөгчийн хөлс олгогдож оны эцэст 123.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй

байна. Малжуулах төсөл хөтөлбөрийн хүрээнд 84.0 сая төгрөгийн санхүүжилт олгож урьдчилж гарсан зардлын авлагаар бүртгэсэн байна. СХС-ийн 83.8 сая төгрөгийн насжилт өндөртэй хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхэнд 133.1 сая төгрөг, оны эцэст 133.2 сая төгрөг болж өсөлт бууралт гараагүй байна. Тайлант онд эм боох материал 3.2 сая төгрөг, хангамжийн материал 10.6 сая төгрөгөөр өсөж, аж ахуйн материал 5.4 сая төгрөг, түлш тослох материал 6.8 сая төгрөгөөр буурч хүнсний материал, тусгай зориулалтын материалд өөрчлөлт гараагүй байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 292.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 43.8 сая төгрөгийн материал авч нийт 336.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 336.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

### **3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7660.1 сая төгрөг байсан бол оны эцэст 8546.0 сая төгрөг болж 885.9 сая төгрөгөөр өссөн нь 12.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 759.6 сая төгрөгөөр хандив, үнэ төлбөргүй, шилжүүлэн авсан 114.0 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 885.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй, хандив, шилжүүлэн авсан хөрөнгөөр нэмэгдэж, 49.6 сая төгрөгийн хөрөнгө акталж, 118.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн ангилал хооронд шилжүүлсэн зэргээр хасагдсан байна.

### **3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 38.3 сая, оны эцсийн үлдэгдэл 19,7 сая төгрөг болж 18.6 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад өгөх өглөгийн барагдуулсантай холбоотой байна. Тайлант онд үүссэн өглөг дараа оны тайлангаар бүрэн барагдах өглөг байна.

Богино хугацаат өр төлбөрийн 19.7 сая төгрөг нь бараа үйлчилгээний, 10.4 сая төгрөг ажилчдад өгөх өглөг 7.7 сая төгрөг, байгууллагад өгөх 1.6 сая төгрөгтэй холбоотой өр төлбөр байна.

### **3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8302.7 сая төгрөг байсан оны эцэст 8644.2 сая төгрөг тайлант онд 341.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 341.5 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүнгээр өссөн байна.

## **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3183.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3183.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 07 өдрийн 02 тоот тогтоолоор 3183.5 сая төгрөгөөр

баталсан байна. Тайлант оны орлого давсантай холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 09 дугаар сарын 06-ны 6/02 тоот тогтоолоор нийт 3253.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 9 дугаар сарын 06-ны өдрийн 6/02 тоот тогтоолоор 3253.1 сая төгрөгөөр 8 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3253.1 сая төгрөгийн төсөв баталснаас 2009.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 753.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 240.3 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 1.2 сая төгрөгийг өөрийн орлогоос, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 206.0 сая төгрөг, ЭМД-ийн санхүүжилтээс 43.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл /сая. Төгрөг/

Байгууллагын нэр	ЭХ ҮҮСВЭР						Хэмнэлт хэтрэлт
	Нийт төлөвлөгөө			Эх үүсвэрийн гүйцэтгэл			
	Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт	
ОН төсөв	753.4	0.6	754.0	747.6	0.6	748.2	5.8
ТЗШ	2,009.1	0.6	2,009.7	1,970.6	0.6	1,971.2	38.5
ЭМД	43.1		43.1	32.9	-	32.9	10.2
ОНХС	194.0	46.3	240.3	194.0	4.9	198.9	41.4
СХС	-	206.0	206.0	-	122.3	122.3	83.7
<b>ОНБ дүн</b>	<b>2,999.6</b>	<b>253.5</b>	<b>3,253.1</b>	<b>2,945.1</b>	<b>128.4</b>	<b>3,073.5</b>	<b>179.6</b>

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1970.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 747.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 194.0 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 1.2 сая төгрөгийг өөрийн орлогоос, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 122.3 сая төгрөг, ЭМД-ийн санхүүжилтээс 32.9 сая төгрөг буюу нийт 3073.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 2967.5 сая төгрөгийн зарлага гаргаж төсөвт 24.5 сая төгрөг төвлөрүүлж мөнгөн хөрөнгийн 155.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2967.5 сая мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь ковид-19 цар тахалтай холбоотой хүүхдийн хоол, үдийн цайны зардлууд бүрэн гараагүйтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 253.5 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.2 сая төгрөг туслах үйл ажиллагааны орлого 4.9 сая төгрөгөөр, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 122.3 сая төгрөгөөр орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогыг дийлэнх хувийг СХС-ийн зээлийн эргэн төлөлт болох 122.3 сая төгрөг эзэлж байна.

Үенч сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 9 дугаар сарын 06-ны өдрийн 6/02 дугаар тогтоолд Үенч сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 177.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 293.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 165.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төгрөг/

д/д	Орлогын нэр төрөл	Орон нутгийн татварын орлого	2021.08.30 ны тогтоолоор	Орлогын гүйцэтгэл	Зөрүү
	Нийт орлогын дүн	157.9	177.8	293.4	(115.6)
А	Нийт орлого тусламжийн дүн	157.9	177.8	293.4	(115.6)
Б	Нийт орлогын дүн	157.9	177.8	293.4	(115.6)

<b>В</b>	Суурь орлогын дүн	<b>157.9</b>	<b>177.8</b>	<b>293.4</b>	<b>(115.6)</b>
	Урсгал орлогын дүн	<b>62.1</b>	<b>177.8</b>	<b>293.4</b>	<b>(115.6)</b>
<b>Г</b>	Татварын орлого	<b>62.1</b>	<b>157.8</b>	<b>281.6</b>	<b>(123.8)</b>
<b>1</b>	Хувь хүний орлогын албан татвар	59.6	56.6	86.8	(30.2)
	Үйл ажиллагааны орлогын татвар	2.0	2.0	5.0	(3.0)
	Хөрөнгийн орлого	44.0	41.0	61.6	(20.6)
	ХХОАТ-ын бусад орлого	13.6	13.6	20.2	(6.6)
<b>2</b>	Өмчийн татвар	2.5	2.5	3.2	(0.7)
	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар			-	-
	Бууны албан татвар	2.5	2.2	2.1	0.1
	Хүүгийн орлого				
	Малын хөлийн албан татвар	-		1.1	(1.1)
<b>4</b>	Бусад орлого	<b>95.8</b>	<b>98.7</b>	<b>191.6</b>	<b>(92.9)</b>
	Улсын тэмдэгийн хураамж	2.1	2.8	3.6	(0.8)
	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.1	1.1	1.8	(0.7)
	Ан амьтан агнах зөвшөөрлийн	81.2	81.2	149.6	(68.4)
	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	1.0	1.0	2.3	(1.3)
	Газрын төлбөр	6.4	6.4	19.8	(13.4)
	Байгалийн ургамалын нөөц ашигласны төлбөр	2.5	3.9	3.6	0.3
	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.5	2.3	10.9	(8.6)
<b>Д</b>	Татварын бус орлого	-	<b>20.0</b>	<b>11.8</b>	<b>8.2</b>
	хүү торгууль				
	Хүү торгуулийн орлого		20.0	11.8	8.2

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлогыг 115.6 сая төгрөгөөр давуулсан. Үүнээс хувь хүний орлогын албан татварыг 6.6 сая, өмчийн орлогыг 0.7 сая, малын хөлийн татвар 1.1 сая, татварын бус орлого 8.2 сая, ан агнуурын хураамжийн орлогыг 68.4 сая, бусад орлого 17.2 сая, газрын төлбөрийн орлогыг 13.4 сая төгрөгөөр давуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМГ-аас 66.3 сая, үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 10.6 сая, дээд шатны төсөв захирагчаас 80.1 сая, хандив тусламжаар 25.9 сая төгрөг нийт 182.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 30.6 сая, эм эмийн хэрэгсэлд 4.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 136.3 сая төгрөг зарцуулж орон нутгийн төсөвт 11.1 сая төгрөг төвлөрүүлж мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2021 онуудад олгосон 83.6 сая төгрөгийн зээлийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлийн үлдэгдэл өндөр дүнтэй байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулсан, сангийн хөрөнгийн үлдэгдэл 123.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй эргэлтэд орохгүй байгаа нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. Урьдчилж гарсан зардалд бүртгэгдсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад санхүүжилт олгоод эргэн төлөх гэрээ байгуулаагүй, тооцоо нийж актаар баталгаажуулаагүй 84.0 сая төгрөгийн асуудал байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

ОНХС-аас ажлаас халагдсан хүний цалинг шүүхийн шийдвэрээр нөхөж олгоод буруутай этгээдээр төлүүлэх нэхэмжлэл гаргаагүй, хөрөнгө оруулалтын санхүүжилт аваад ажлаа дутуу хийсэн, зарим ажлууд зураг төсөв байхгүй, хүлээн авсан комиссын гарын үсэг дутуу, мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, анхан шатны баримт дутуу, сангийн журам зөрчсөн зэрэг асуудлууд санхүүгийн тайланд нөлөөлж байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн оруулаагүй, 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүрээр мэдээлэх мэдээллийг огт оруулаагүй байна.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Мэдээлээгүй болон дутуу мэдээлсэн мэдээллийг аудитын явцад бүрэн оруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 176.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 18.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 19.1 сая төгрөгийн 3 алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн байгааг 70% хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийн зардал, ковид-19 цар тахал, шүлхий өвчинтэй холбоотой зардлууд, ЭМТ-ийн оношлуур болон шатахууны зардлын зарцуулалт, үндсэн хөрөнгө, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай холбоотой асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2 (Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв), “Хязгаарлалттай” 1 (Ерөнхий боловсролын сургууль) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Үенч сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 360.6 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрч, 98.2 сая төгрөгийн 4 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 262.4 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 6.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 255.6 сая төгрөгийн 12 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Нийт илэрсэн алдаа зөрчил		Үүнээс залруулсан		Хүснэгт -5 /сая.төг/					
						Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		тоо	дүн	тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
2	Сургууль	6	215.0	1	0.1					5	214.9
3	Цэцэрлэг	5	17.8			1	5.1			4	12.7
4	ЭМТ	7	127.8	3	98.1	1	1.7			3	28.0
		<b>18</b>	<b>360.6</b>	<b>4</b>	<b>98.2</b>	<b>2</b>	<b>6.8</b>	-	-	<b>12</b>	<b>255.6</b>

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 725.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 212.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 24.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 259.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага бичиж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 229.2 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээ хийсэн байгаа 53.5 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд баримтжуулсан
2. Бараа материал худалдан авсан тухай бүрд нярваар орлого авч тооцоо хийж, зарлагадахдаа нярав албан хаагчдаар шаардах хуудас бүрэн бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж зөвшөөрсөн тохиолдолд олгоогүй, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулж, хяналт тавин үнэн зөв бодитой хийгээгүй 16.0 сая төгрөгийг зөрчлийг аудитын явцад засуулсан

3. ХХААГ-ын 2021 оны 6 дугаар сарын 21-ны 255 тоот албан тоот, аймгийн ИТХ-ын 2021 оны 06 сарын арван 07-ны 43 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй орлогод авах Герефорд шилмэл үүлдрийн хээлтүүлэгч 4.9 сая төгрөг, өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн мал шүршигч мотпомп 1.1 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр үндсэн хөрөнгийн орлогод бүртгэх өв соёлын хүрээлэн 136.4 сая төгрөгийн өртөгтэй, бага үнэтэй түргэн элэгдэх зардал болох 149.9 сая төгрөгийн ус буцалгаагчийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгэсэн

Шийдвэрлэсэн нь: Шалгаагдагч байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 212.3 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

## 4.2 Төлбөрийн акт

### 4.1.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин томилолт илүү олгосон 3.7 сая төгрөг, Санхүүгийн дотоод хяналт аудитын албаны төлбөрийн акт болох 1.7 сая төгрөгийг ажилтнуудтай холбогдох тооцоолол хийгээгүй төсвөөс төлсөн, нийт 4.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн", 20 дугаар зүйлийн 20.2.5. "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс актын төлбөр төлснийг төсөвт буцаан төвлөрүүлэх 4.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоох

### 4.1.2 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гэрээний үүргээ биелүүлээгүй урьдчилж авсан санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан байхгүй, гүйцэтгэлийн явцын хяналт хэрэгжүүлээгүй, гэрээ сунгаагүй, алданги тооцоогүй, ЗХЗ-ийг суутгаж аваагүй 19.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалагчийн хяналтын зардал суутгаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй 19.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоох.

## 4.3 Албан шаардлага

### 4.3.1 СХС-ийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: СХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, тооцоо нийлж баталгаажуулаагүй 83.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь зээлдэгчтэй байгуулсан гэрээний 7.2.4-д "Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ", 8.2-д "Зээлдэгч зээлийн төлбөрийг сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу төлнө", 9.2-д "Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд Зээлдүүлэгч гэрээг цуцалж, зээл, хүү нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ. Үүнд: 9.2.1-д "Зээлийн гэрээний 3.2-т зааснаас өөр зориулалтаар ашигласан", 9.2.2-д "Зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн", 9.2.4-д "Гэрээгээр хүлээсэн үүргээ 2-оос дээш удаа зөрчсөн, эсвэл 15 дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн бол", ХХААХҮС-ын 2021.07.06-ны 01/2191 тоот чиглэл" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага бичих

#### **4.3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт. Ажлаас халагдсан ажилтанд төсвөөс цалин олгоод буруутай этгээдээс нэхэмжилж аваагүй, авлагад тусгаагүй 11.8 сая төгрөгийн 2 зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага иргэний хуулийн 498.5-д заасны дагуу нэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс олгосон цалинг буруутай этгээдээс гаргуулж төсвийн хохиролгүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 албан шаардлага бичлээ.

#### **4.3.3 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Ажлаа дутуу хийсэн, зарим ажлууд зураг төсөв байхгүй, хүлээн авсан комиссын гарын үсэг дутуу, мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, малжуулахаар өгсөн санхүүжилтийн эргэн төлөлт тодорхой бус 163.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага бичлээ

### **4.4. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **4.1.6 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагуудын нэмэлт дансаар хийсэн санхүүжилтийн баримт байхгүй, хүлээн авсан актаар баталгаажаагүй, зарим хөрөнгө орлого аваагүй 49.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ОНХСан-ийн үйл ажиллагааны журмын 4-р зүйлийн 4.2.5-д "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, и-баримтыг хавсаргах, хөрөнгө бүрэн орлого авах

#### **4.1.7 Төсвийн зарлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ИТХ-нь Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй 41.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2021/02/17-ны 43 тоот "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3, 1.6, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өглөө.*

#### **4.1.8 Авлагатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Насжилт өндөртэй авлага бууруулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхой бус 118.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Авлага бууруулж ажиллах, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах 2 зөвлөмж өглөө.*

#### **4.1.9 Бараа материалын тайлан, тооллоготой холбоотой асуудал**

*Илрүүлэлт: И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг хийсэн бараа материалын тайлан гаргалт хангалтгүй, шатахууны тооцоо бодоогүй 19.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж Бараа материал худалдан авсан тухай бүрд нярваар орлого авхуулж, зарлагадахдаа нярав нь албан хаагчдаар шаардах хуудас бүрэн бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж зөвшөөрсөн тохиолдолд олгож хэвших, бараа материалын тооллогыг үнэн зөв бүрэн хэрэгжүүлэх*

#### **4.1.10 Шилэн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүйтэй холбоотой хуулийн хэрэгжилт хангалтгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн шилэн дансны зарчим, 6 дугаар зүйлийн шилэн дансны мэдээлэл заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. ТТЗ-ын тайлангаар болон түүврийн байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дарви ТТЗ	1	111.2							1	111.2
2	Дарви ЗДТГ	8	285.3	3	212.3	1	4.9			4	68.1
3	Дарви ИТХ	-	-								
4	Дарви сумын Соёлын төв	1	2.0					1	2.0		
5	Дарви сумын ОНХС	4	242.8			1	19.6	2	173.3	1	49.9
6	Дарви сумын СХС	1	83.9					1	83.9		
	<b>Дүн</b>	<b>15</b>	<b>725.2</b>	<b>3</b>	<b>212.3</b>	<b>2</b>	<b>24.5</b>	<b>4</b>	<b>259.2</b>	<b>6</b>	<b>229.2</b>

### ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР